



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

"Мөнх цамц мод" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 15 дугаар зүйлийн 15.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 405 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Мөнх цамц мод" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Мөнх цамц мод" ХЗХ /Д.Адъяамөнх/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолыг олон нийгэд мэдээлэхийг Тамгын газар /Л.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦӨГЭГЧ,
ДЭД ДАРГА  БАТБОЛД



000126